

Төсөл
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн
сайдын 2024 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ... дугаар хамтарсан тушаалын
нэгдүгээр хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ШОШГОД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Монгол Улсад үйлдвэрлэсэн согтууруулах ундааны шошго нь Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт зааснаас гадна дараах мэдээллийг агуулсан байна.

Үүнд:

- 1.1. Хадгалах хугацаа;
 - 1.2. Зураасан код;
 - 1.3. Анхааруулгын загвар.
2. Монгол Улсад үйлдвэрлэх согтууруулах ундааны шошго нь монгол хэлээр байна.
3. Шошгод дээрх шаардлагаас гадна дараах нэмэлт мэдээлэл тавьж болно:
- 3.1. Барааны болон олон улсын үзэсгэлэн, уралдаанаас авсан шагналын тэмдэг, зохистой дадал, чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн тухай мэдээлэл;
 - 3.2. Хадгалах хугацаа, хэрэглэж дуусах хугацаа, үйлдвэрлэсэн огноо, хадгалах нөхцөлийг агуулсан QR код бүхий мэдээлэл.
4. Шошгод агуулагдах нэмэлт мэдээллийг олон улсын болон Монгол Улсын техникийн зохицуулалт, стандартаар зохицуулж болно.
5. Гадаад улсад экспортлох бол “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг болон энэхүү тушаалаар батлагдсан “Согтууруулах ундааны шошго, анхааруулгыг загварт тавигдах шаардлага”-ыг мөрдөхгүй байж болно.
6. Согтууруулах ундааны шошгод эрүүл мэндийн мэдэгдэл байршуулахыг хориглоно.
7. Согтууруулах ундааны шошгын мэдээлэл үнэн зөв эсэхийг тухайн үйлдвэрлэгч хариуцна.
8. Согтууруулах ундааны шошгод хүний эрүүл мэндэд нөлөөлөх хор хөнөөл, гаж нөлөө, хориглох заалтыг тусгасан анхааруулгын загварыг шошгод байршуулна.
9. Анхааруулгын загвар нь шошгын нийт талбайн 20 хувиас багагүй байна.
10. Анхааруулгад дараах бичвэрээс сонгож байршуулна.
- 10.1. Хавдар болон ургийн гажиг үүсгэх эрсдэлтэй.
 - 10.2. Тархины үйл ажиллагааг дарангуйлдаг ба мэдрэлийн эсийг үхүүлдэг.
 - 10.3. Хэтрүүлэн хэрэглэх нь гэмт хэрэг, хүчирхийлэлд хүргэнэ.
 - 10.4. Бусдыг согтууруулах ундаа хэрэглэхийг шаардахыг хориглоно.
11. Анхааруулгын загварын бичвэрийг монгол хэлээр бичнэ.

Төсөл
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн
сайдын 2024 оны ... дугаар сарын ...-
ны өдрийн ... дугаар хамтарсан
тушаалын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХОР НӨЛӨӨНИЙ АНХААРУУЛГЫН ЗАГВАР

Анхааруулгын загварт дараах зурган тэмдэглэгээг байршуулна.

№	Анхааруулгын агуулга	Загвар
1	Хорин нэг нас хүрээгүй хүн хэрэглэхийг хориглоно.	
2	Жирэмсэн хүн хэрэглэхийг хориглоно.	
3	Тээврийн хэрэгсэл жолоодож байгаа хүн хэрэглэхийг хориглоно	